

Үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүлэгчдийн  
2024 оны 1 дүгээр сарын 05 ны өдрийн хурлын  
№02 дугаартай тогтоолын 1 дүгээр хавсралт

## ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН АЖИЛЧДЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ДҮРЭМ

### Ерөнхий зүйл

Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах, хууль дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, нийгэм эдийн засгийн ашиг сонирхлыг төлөөлөн хэрэгжүүлэх, хөдөлмөрлөх нөхцөл эрүүл ахуйд анхаарал тавих, гишүүдийг хөгжүүлэх, шагнаж урамшуулахад оршино.

### Нэг. Хорооны зорилго

1.1 Хороо нь хуулийн этгээд болохын хувьд эв нэгдэл, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн хууль дүрмийн хүрээнд гишүүдээ төлөөлөн ажил олгогчтой хамтын гэрээ байгуулж хэрэгжүүлэн ажиллана.

1.2 Удирдах дээд байгууллагын хувьд мэргэжил арга зүйгээр нэгдсэн холбоонд гишүүнчлэгдэж, нутаг дэвсгэрийн шинжээр нэгдсэн ҮЭ-ийн холбоонд харьяалагдаж хууль дүрмийн хүрээнд гишүүдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангаж ажиллана.

### Хоёр. Бүтэц, үйл ажиллагаа

2.1 Хороо нь нэг орон тооны дарга, гэрээт нягтлан бодогч, цех хэсэг, нэгж бүрийг төлөөлсөн арванхоёр тэргүүлэгчээс бүрдэнэ. Хорооны дарга нь удирдах дээд байгууллагын дүрэмд зааснаар сонгогдож, гишүүддээ тайлан тавьж ажиллана. Тэргүүлэгчдийг цех хамт олны хурлаас сонгож, бүх гишүүдийн хуралд танилцуулан батална. Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон Хянан шалгах комисстой /ХШК/ байна.

2.2 Нийт тэргүүлэгчдийн 50 иас дээш хувь нь хуралд ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

8.3 ҮЭ-ийн байгууллагын үүссэн тэгш ой, байгууллагын тэгш ой, ЭХ-ний салбарын ажилтнуудын өдрийн арга хэмжээ, бусад баярын үеэр ҮЭ-ийн үйл хэрэгт идэвх санаачлагатай оролцож, сайн үйлсийн төлөө ажилласан гишүүдийг дээд байгууллагын болон бусад шагналд тодорхойлно.

8.4 ХАБЭА-н болон ажил мэргэжлийн бусад төрлөөр мэдлэг сорих тэмцээн зохион байгуулж амжилттай оролцогсодыг мөнгөн шагналаар шагнаж урамшуулна. /жил бүр төсөв, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ/

8.5 Эрчим хүчний салбарт ажиллагсадын өдрөөр цех, салбар, нэгж хэсгүүдэд 40 хүртэлх хүнтэй бол нэг, 40 өөс дээш хүнтэй цех хамт олонд хүсэлтийн дагуу хоёр хонь, ашиглалт, засварын уралдаанд амжилт гарган тэргүүлсэн хамт олонд аялалд явахад нь тус бүр хоёр хонь олгож урамшуулна /байгууллагын үнээр мөнгөн дүнд шилжүүлэн өгч болно/

8.6 ҮЭ-ийн хорооны нэрэмжит уламжлалт тэмцээний төрлүүд:

- Снукер биддъярд
- Цэргийн баяр угтсан Үндэсний бөхийн барилдаан
- Нэгдсэн ээлжүүдийн дундах олон төрөлт спортын тэмцээн /Цом авсан ээлж хариуцан зохион байгуулах/
- Засварын бригадуудын дундах спортын олон төрөлт тэмцээн /Цом авсан цех зохион байгуулах/
- ИТА нарын дундах спортын олон төрөлт тэмцээн /Цехийн дарга нар санаачилсан, зохион байгуулах/
- Городки
- Байгууллагын шатрын аварга баг шалгаруулах тэмцээн

8.7 Төлөвлөгдсөн ажлын төсөв зардал, нийгмийн дэмжлэгийн зардлыг баримт бичиг, өргөдөл хүсэлтийг үндэслэн судалж үзээд дарга нягтлан бодогч нар тухайн үед нь олгож ажиллана.

### **Ес. Дүрмийг хэрэгжүүлж ажиллах талаар**

9.1 Энэ дүрмийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөх ба нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг холбогдох санал бичгээр ирсэн тохиолдолд оны эхний улиралд багтаан хэлэлцэж болно.

9.2 ҮЭ-ийн хорооны сонгуультнуудын зохион байгуулалт, сонгуулийн үйл явц болон ҮЭ-ийн гишүүдийн эрх үүрэг, ХШК-ын үйл ажиллагаа, хэм хэмжээ энэ журамд заагдаагүй ба эвлэлдэн нэгдсэн ҮЭ-ийн удирдах байгууллагуудын дүрэм журмаар зохицуулагдна.

6.1.5 Соёл олон нийтийн ажилд 15 хувь

6.1.6 Томилолт бичиг хэргийн зардал 15 хувь

6.1.7 Эв нэгдлийн санд 2 хүртэл хувь

6.1.8 Үндсэн хөрөнгө 3 хүртэл хувь /хороо нь санхүүгийн боломжинд тулгуурлан шаардлагатай хөрөнгийг худалдан авч болох бөгөөд тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ

6.2 ҮЭ-ийн хорооны даргын цалин нь хамтын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу ажилтнуудын цалин нэмэгдэхэд дагаж нэмэгдэх бөгөөд тэргүүлэгчдийн тогтоолоор баталгаажуулах, нягтлан бодогчийн цалин, тэргүүлэгчид, хянан шалгах комиссын гишүүдийн урамшуулал, гэрээт ажилтны цалингийн хэмжээг тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн тогтооно.

6.3 Төлөвлөгөөт зардлаас гадна төлөвлөгөөт бус зардлыг төсөвлөж хурлын тогтоолоор шийдвэрлэн зарцуулж болно.

6.4 Ажлын зайлшгүй шаардлагаар журамд заагдсан болон төлөвлөгөөт бус 500.000 /таван зуун мянган төгрөг хүртэл үнийн дүнд яаралтай зардлыг дарга нягтлан бодогч нар баримт хүсэлтийг үндэслэн шийдвэрлэж болно.

#### **Долоо. Нийгмийн дэмжлэг тусламж**

7.1 Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болон гал түймрийн улмаас орон гэргүй болсон гишүүнд нэг удаа 200.000 /хоёр зуун мянга/ төгрөг олгоно

7.2 Гишүүн нас барсан тохиолдолд ар гэрт нь 500.000 /таван зуун мянга/ төгрөг олгоно


7.3 Хуанлийн 40 хоногоос дээш хугацаагаар өвчилж хөдөлмөрийн чадвараа түр алдсан гишүүнд нэг удаа 400.000 /дөрвөн зуун мянга/ төгрөг олгоно

7.4 Дээрх нөхцлүүдээс гадна зайлшгүй шаардлагаар тусламж үзүүлэхийг хүссэн хүсэлтийг харгалзан тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж тусламж дэмжлэг үзүүлж болно

#### **Найм. Шагнаж урамшуулах нөхцөл, хэмжээ**

8.1 Соёл олон нийтийн идэвхжүүлэлтийн арга хэмжээг тухайн жилээр нь төлөвлөн баталж холбогдох зардлыг гаргана.

8.2 Жил тутам шилдэг гишүүдийг шалгаруулж гадаад, дотоодын аялал, амралт сувилалд явах эрхээр шагнана. /шалгаруулалтыг тусгай журмаар/



4.9 Хууль бус үйлдэл гаргасан, хөрөнгө санхүүгийн дутагдал үүсгэсэн, хувьдаа завшсан нь тогтоогдсон тохиолдолд Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээнэ.

#### **Тав. Даргын эрх, үүрэг, хариуцлага**

5.1 ҮЭ-ийн хорооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж тэргүүлэгчдийг удирдан чиглүүлж ажиллах үүрэгтэй.

5.2 Гишүүдээс ирсэн өргөдөл, санал хүсэлтийн дагуу тэдэнд тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажил олгогчийн төвшинд хэлэлцэн шийвэрлэх үүрэгтэй.

5.3 Хороог төлөөлж хурал, чуулган, зөвлөгөөн, сургалтуудад хамрагдаж цаг үеийн үйл явдлыг байгууллага дээр хэрэгжүүлэх, гишүүдэд мэдээ мэдээлэл хүргэх, зохион байгуулах үүрэгтэй.

5.4 Тэргүүлэгчид, нягтлан бодогч бусад орон тооны бус зөвлөлүүдээс хүлээсэн үүрэгтэй нь холбоотой шаардлага тавих, хариуцлага хүлээлгэх эрхтэй

5.5 “ДБЭХС” ТӨХК-ийн ҮЭ-ийн хороотой холбоотой үйл ажиллагаа, санхүүгийн зарцуулалт, дүрэм журмын хэрэгжилт зэрэг бүхий л үйл явцад хариуцлага хүлээхийн зэрэгцээ Монгол улсын хуулиуд, ҮЭ-ийн эрхийн тухай хуулийн дагуу төлөөлөх эрхтэй

5.6 Гишүүдэд ОУ-ын гэрээ конвенц, ҮЭ-ийн эрхийн тухай хуулиар олгогдсон чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг эдэлх боломжийг бүрдүүлэх, эвлэлдэн нэгдсэн Үйлдвэрчний эвлэлүүдийн дүрэм журмыг мөрдөж ажиллах үүрэгтэй.

5.7 Эвлэлдэн нэгдсэн удирдах байгууллагуудын дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

#### **Зургаа. Санхүүгийн захиран зарцуулалт**

6.1 Хороо нь бүх гишүүдийн хурлаас шийдвэрлэн эвлэлдэн нэгдсэн удирдах байгууллагын журамд зааж, чиглэл болгосоны дагуу төсөв баталж ҮЭ-ийн хорооны мөнгөн хөрөнгийг зарцуулна.

6.1.1 Үндсэн зардал 40 хүртэл хувь /цалин, урамшуулал, НДШ, татвар/

6.1.2 Сургалт, судалгаа, сурталчилгаа 15 хувь

6.1.3 Нийгмийн хамгаалал, дэмжлэг, буцалтгүй тусламж 5 хувь

6.1.4 Гишүүдийг шагнаж урамшуулах 5 хувь

3.9 Хорооны бүхий л үйл ажиллагаатай холбоотой асуудалд оролцож өөрийн төлөөлж буй гишүүдийн өмнөөс шийдвэр гаргах эрхтэй.

3.10 Тэргүүлэгчийн үүрэгт ажлаа гүйцэтгэсэний төлөө аливаа дарамт шахалтад өртсөн тохиолдолд хуулиар хамгаалуулах эрхтэй.

3.11 Тэргүүлэгч нь өөрийн төлөөлж буй хамт олны өмнө тулгамдсан, ҮЭ-ийн хороогоор дамжуулан шийдвэрлүүлэх боломжтой асуудлыг мэдсэн боловч илэрхийлээгүй даамжруулсан тохиолдолд хариуцлага хүлээнэ.

3.12 Хамт олондоо болон бусад нэгж хэсгийн гишүүдэд худал цуурхал тараах замаар санаатай хорооны нэр хүндийг гутаах үйлдэл гаргасан, аливаа үйл ажиллагаа, хамтын шийдвэрийг үл хүндэтгэн гишүүдэд буруугаар ухуулан таниулж ҮЭ-ийн үйл хэргэг, үр дүнгийн эсрэг ажилласан, гишүүдийг төөрөгдүүлж худал мэдээлэл өгсөн тохиолдолд хариуцлага хүлээнэ. /Тэргүүлэгчээр сонгосон хамт олны хурлыг зарлан хэлэлцүүлэх, тэргүүлэгчийн эрхийг хасах хүртэл/

#### **Дөрөв. Нягтлан бодогчийн эрх, үүрэг, хариуцлага**

4.1 Хорооны санхүүгийн үйл явц, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус зардлын талаар сар бүр тэргүүлэгчдийн хуралд мэдээлэх үүрэгтэй.

4.2 Нягтлан бодогч нь тогтоол шийдвэрийн дагуу мөнгөн гүйлгээг цаг алдалгүй хийж баримтыг хавсарган хянуулж архивлах үүрэгтэй.

4.3 Хорооны хурал зарлах, зохион байгуулах, байгууллагын санхүүгийн хэлтэс, бусад нэгж хэсгүүдтэй санхүүгийн дотоод тооцоо нийлэх, бусад ажлын зохион байгуулалтад идэвх санаачлагатай оролцох үүрэгтэй.


4.4 Банк, санхүүгийн байгууллагуудтай холбогдож хөрөнгийн зарцуулалт, хадгаламж үйлчилгээний оновчтой шийдлийг судлан хэрэгжүүлэх үүрэгтэй

4.5 Хорооны өмч хөрөнгийн бүртгэл хөтөлж, жил бүр тоолж бүртгэн баталгаажуулж тайлангийн хуралд мэдээлэх үүрэгтэй.

4.6 Санхүүгийн мэдээ тайланг хагас жилээр гарган гишүүд, ХШК-д мэдээлэх, бүтэн жилээр нэгтгэн тайлангийн хуралд танилцуулах үүрэгтэй.

4.7 Мөнгөн хөрөнгийн зарцуулалтын анхан шатны баримтыг холбогдох хүлээн авагчаас шаардан авч үдэж архивлах, санхүүгийн баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллах үүрэгтэй.

4.8 Аливаа мөнгөн гүйлгээг хийхдээ үндэслэл бүхий баримт бичиг, тогтоол шийдвэр, даргын зөвшөөрлийг үндэслэн гүйцэтгэнэ.



2.3 Яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудал бүхий, цаг хугацаатай гишүүдийн өргөдөл хүсэлтийг хэлэлцэх тохиолдолд хурлыг цахим байдлаар зохион байгуулж, хурлын тэмдэглэлээр баталгаажуулан асуудлыг шуурхай хэлэлцүүлэх шийдвэрлүүлэн ажиллаж болно.

2.4 Хороо нь батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу зохион байгуулсан ажлын тайланг хагас жилд цахим болон хэвлэх байдлаар, бүтэн жилийн тайланг бүх гишүүдийн хурал зохион байгуулж танилцуулна.

2.5 Хорооны дарга гурван сараас дээш хугацаагаар эзгүй байх тохиолдолд орлох хүнийг даргын санал оруулсанаар тэргүүлэгчдийн хурлаас томилно.

### **Гурав. Тэргүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага**

3.1 Тэргүүлэгчид нь үйл ажиллагааны чиглэлээр дэд хороо болон хуваарилагдаж, хариуцсан дэд хорооны асуудал болон өөрийн хариуцсан хамт олны тулгамдсан асуудлыг төлөөлөн илэрхийлэх, шийдвэрлүүлэх арга замыг судлан цаг зав, сэтгэл зүрхээ зориулан ажиллах үүрэгтэй.

3.2 Гишүүдийн байр суурийг үнэн зөв, чөлөөтэй илэрхийлж үүнийхээ төлөө тууштай зогсож үйлдвэрчний эвлэлийн нэгдмэл байдлын илэрхийлэл болж ажиллах үүрэгтэй.

3.3 Улирал тутамд дэд хорооны ажлын товч тайлан бэлтгэж хорооны даргад танилцуулан, зөвлөлдөх байдлаар ажлын үр дүнг сайжруулахад анхаарах, санал санаачилага гарган ажиллах

3.4 Удирдах ажилтнуудын харилцаа хандлага, үндэслэлгүйгээр үр дүнгийн нэмэгдэл хөлсийг хассан, нэмсэн тохиолдол гарвал хорооны даргад мэдэгдэж, хамтын гэрээний 8.2 заалтыг хэрэгжүүлэн, дутагдлыг арилгуулах, ажилтнуудын сэтгэл хангалуун хөдөлмөрлөх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

3.5 Даргын зүгээс өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд анхаарч, аливаа үйл ажиллагааны зохион байгуулалтад идэвх санаачлагатай байж, хамт олноо уриалан оролцуулах үүрэгтэй.

3.6 Гишүүдийг төлөөлөн хурал чуулган, зөвлөгөөн, салбарын удирдах байгууллагуудын уулзалт, тэмцэл хөдөлгөөнд оролцох үүрэгтэй.

3.7 Хамтын гэрээнд заагдсан болон бусад хууль, дүрэм, журмуудын заалтуудын хэрэгжилтийг нэгж хэсгүүдийн удирдлагуудаас шаардах эрхтэй.

3.8 Гишүүдийг аливаа шагнал урамшуулалд тодорхойлох, шилдэг гишүүдийг шалгаруулах үед өөрийн төлөөлсөн хэсгийн гишүүдийн болон өөрийн нэрийг дэвшүүлэх эрхтэй.